

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 05					Улаанбаатар хот	
№	Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт /дэд зорилт/	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Сүүрв түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО						
1	3.1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөж, ил тод мэдээлнэ. 3.1.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний "Шилэн байгууллагуудын дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангуулна.	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллагуудын Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж олон нийтэд төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг хангуулах	100%	100%	Сонгинохайрхан дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон харьяа нийт 117 байгууллага (орон нутгийн байгууллага 12, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар 3, сургууль 29, Насан туршийн суралцахуйн төв 1, цэцэрлэг 71, Хүүхдийн сэргээн засах клиник төв 1), төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй нийт 26 өрхийн эрүүл мэндийн төв, бүгд 143 байгууллагын 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1, 2, 3 дугаар улирал, 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 дүгээр саруудын шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд хяналт шалгалт, нийцлийн аудитыг тус тус гүйцэтгэлээ. 2025 оны эхний 11 сарын байдлаар төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний болон төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй төрийн бус өмчийн нийт 143 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байна	100.0%
ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО						
2	5.1. Засаглал, цахим шилжилтийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ. 5.1.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсөв,	Төсвийн хөрөнгийн санхүүжилт, зарцуулалт түүний үр ашигтай байдлалд хяналт тавих	100%	100%	Дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2025 онд 8 байгууллагад дотоод аудит, 36 байгууллагад санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 42 байгууллагад	102.2%

санхүү, эд хөрөнгийн ил тод байдалд хяналт тавих					төлөвлөгөөт, 1 байгууллага, 2 сэдэвчилсэн төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж хяналт шалгалтын жилийн төлөвлөгөөний биелэлт 102.2 хувьтай байна. <u>Төлөвлөгөөт аудит, санхүүгийн хяналт шалгалтын талаар:</u> Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан СХШУТ/2025-01 дүгээр удирдамжийн хүрээнд 12 өрхийн эрүүл мэндийн төв /Ариун-Энэрэл, Одонт манал, Эхэн босго, Энх-Элбэрэл, Арвин мэнд, Гурванжаргалхайрхан, Гурван тэрх, Мичид асрал, Өлзийт манал, Энх-Ачит, Гурванцүүр, Батцэцэн/-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд, СХШУТ/2025-02 дугаар удирдамжийн хүрээнд Газар зохион байгуулалтын 1,2 дугаар албаны 2023-2024 оны газрын төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлт, өглөг, авлагын байдалд, СХШУТ/2025-03 дугаар удирдамжийн хүрээнд 18 цэцэрлэг /55, 117,125, 170, 188, 214, 215, 244, 252, 259, 261, 264, 270, 271, 286, 316, 328, 330/-ийн 2024 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд, СХШУТ/2025-06 дугаар удирдамжийн хүрээнд 4 сургууль /104, 124, 143, 151/, Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалтыг, ДАТ/2025-07 дугаар удирдамжийн хүрээнд орон нутгийн 6 байгууллага //-ын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод аудитыг тус тус гүйцэтгэсэн. 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан дүүргийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн зарцуулалтыг Нийслэл дэх Төрийн аудитын газар шалгасан, Дэд бүтэц хөгжлийн алба ОНӨААТҮГ-ын 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийх гүйцэтгэлийн дотоод аудитыг дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд Засаг
---	--	--	--	--	--

				даргын шийдвэрийн дагуу дотоод аудитыг түр хугацаагаар хойшлуулсан болно. <u>Төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтын талаар:</u> Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн 2024 оны хууль тогтоомж, дээд газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, гэрээ, санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд болон аж ахуйн тасгийн хүлээсэн үүргийн хэрэгжилтэд, Дүүргийн Засаг дарга бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан СХШУТБ/2025-05 дугаар удирамжийн хүрээнд төвийн шугамд холбогдоогүй бохир ус соруулдаг орон нутгийн 6 байгууллага, 18 сургууль, 40 цэцэрлэг нийт 64 байгууллагын 2023-2025 оны бохир ус соруулалт, түүний тээвэрлэлийн байдалд, СХШУТБ/2025-08 дугаар удирдамжийн хүрээнд СХД-ийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төв, 26 сургууль, 47 цэцэрлэг, нийт 76 байгууллагад 2024-2025 онд орон нутгийн төсвөөс хуваарилсан урсгал засварын зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд тус тус төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэсэн.	101.1%
НИЙТ ДҮН /хувиар/					



ХЯНАСАН:
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ДОТООД
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА

Д.ТӨМӨРБААТАР

БИЕЛЭЛТ ГАРҮҮСАН:
АХЛАХ ДОТООД АУДИТОР

Г.ЭНХЗУЛ